



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2026/075/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэбулган хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn Цахим актив аудит ХХК: Аудитор: Д.Эрдэнэцэцэг Утас: 99019943 Цахим хаяг: tsakhimactive@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.08.25 № 119
танай _____-ны № _____-т

ЖАРГАЛАНТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Д.ПҮРЭВДОРЖ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь 70 нэр төрлийн 78,020.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, 33,020.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 11,176.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй орлогоор авсан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 18235 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлснээр Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох санхүүжилтээр 1,489,200.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардалд 43,989.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, төрийн сангийн харилцах дансанд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Тайлант онд эм, эм боох материалын үлдэгдэлд 8464 нэр төрлийн 12,406.3 мянган төгрөгийн үлдэгдэл байгаагаас 1486 нэр төрлийн 1,754.1 мянган төгрөгийн он дамжсан эмийн үлдэгдэл, 35 нэр төрлийн 4,653.5 мянган төгрөгийн эмийн нөөц, 6943 нэр төрлийн 5,998.7 мянган төгрөгийн тусгай зориулалтын материалын үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсөв захирагчаас 92.8 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	181,303,578.44	53,184,545.21
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	550,137.37	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	550,137.37	-
3121	Төгрөг	550,137.37	-
31211	Төрийн сангийн харилцах	550,137.37	-
33	АВЛАГА	122,014,901.18	2,479,399.73
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	122,014,901.18	2,479,399.73
35	БАРАА МАТЕРИАЛ	58,738,539.89	50,705,145.48
351	Түүхий эд материал	30,513,939.89	14,758,285.48
35110	Тусгай зориулалттай материал	8,882,200.00	2,352,000.00
35130	Эм боох материал	21,631,739.89	12,406,285.48
354	Хангамжийн материал	28,224,600.00	35,946,860.00
35410	Бичиг хэргийн материал	1,200,000.00	1,900,000.00
35420	Аж ахуйн материал	22,847,600.00	19,512,900.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,600,000.00	3,800,000.00
35460	Хүнсний материал	-	1,184,960.00
35470	Бусад хангамжийн материал	2,577,000.00	9,549,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	638,370,548.15	591,265,965.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	638,370,548.15	591,265,965.55
392	Биет хөрөнгө	625,392,548.15	577,167,965.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	407,703,325.15	407,703,325.15
39202	Хуримтлагдсан элэгдэл	(83,412,292.57)	(99,535,941.25)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	214,059,408.00	214,059,408.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(64,874,824.47)	(97,863,574.61)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	246,528,384.50	207,032,131.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	(135,071,944.65)	(90,646,313.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,672,750.00	56,000,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,232,361.47)	(19,589,111.39)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,464,340.00	710,948.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,444,236.34)	(702,906.32)
393	Биет бус хөрөнгө	12,978,000.00	14,098,000.00
39301	Програм хангамж	-	1,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(80,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	12,978,000.00	12,978,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	819,674,126.59	644,450,510.76
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	51,652,209.83	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	51,652,209.83	-
413	Өглөг	51,652,209.83	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	30,121,828.83	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,620,000.00	-
4136	Бусад өглөг	17,910,381.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	17,910,381.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	768,021,916.76	644,450,510.76
51	Засгийн газрын хувь оролцоо	768,021,916.76	644,450,510.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	256,039,232.37	256,039,232.37
51101	Өмч: - төрийн	256,039,232.37	256,039,232.37
512	Хуримтлагдсан үр дүн	290,682,697.88	167,111,291.88
51210	Өмнөх үеийн үр дүн	290,682,697.88	290,682,697.88
51220	Тайлант үеийн үр дүн	-	(123,571,406.00)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	221,299,986.51	221,299,986.51

Жаргалант сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	819,674,126.59	644,450,510.76
---	--	----------------	----------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,234,431,310.30	1,447,098,016.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,025,000.00	33,994,275.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,025,000.00	33,994,275.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,500,000.00	33,994,275.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		11,176,036.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		22,818,239.00
120009	Бусад орлого	525,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,230,406,310.30	1,413,103,741.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,017,700.00	43,439,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,017,700.00	43,439,100.00
1330	Төсвийн захирагчдаас	-	113,423,019.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	-	113,423,019.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,204,388,610.30	1,256,241,622.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,204,388,610.30	1,256,241,622.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,323,217,724.29	1,570,669,422.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,323,217,724.29	1,570,669,422.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,323,172,127.23	1,457,955,515.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	855,072,940.00	969,642,023.13
210101	Үндсэн цалин	495,405,457.00	440,551,614.69
210102	Нэмэгдэл	264,274,221.40	395,546,136.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,861,000.00	32,977,900.00
210104	Урамшуулал	75,532,261.60	100,566,372.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,531,690.28	124,280,660.69
210201	Тэтгэврийн даатгал	71,110,447.89	81,893,160.69
210202	Тэтгэмжийн даатгал	8,502,551.65	10,573,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,536,216.75	5,329,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,867,300.68	5,329,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,515,173.31	21,155,200.00

Жаргалант сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,472,102.94	23,919,360.89
210301	Гэрэл, цахилгаан	5,172,102.94	3,819,360.89
210302	Түлш, халаалт	16,000,000.00	19,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	94,804,917.20	94,168,438.00
210401	Бичиг хэрэг	4,549,850.00	8,896,000.00
210402	Тээвэр, шатахуун	60,297,470.00	34,822,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,249,999.40	5,240,132.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,767,500.00	2,541,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,164,450.00	10,529,850.00
210408	Бараа материал акталсны зардал	13,775,647.80	32,138,056.00
2105	Нормативт зардал	114,296,759.20	110,338,636.19
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	92,458,409.20	94,167,196.19
210502	Хоол, хүнс	21,838,350.00	16,171,440.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,110,200.00	4,860,000.00
210604	Урсгал засвар	6,110,200.00	4,860,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,920,000.00	11,195,000.00
210702	Дотоод албан томилолт	6,920,000.00	11,195,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,050,000.00	8,046,278.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	6,552,600.15
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	1,244,178.00
210803	Даатгалын үйлчилгээ	50,000.00	22,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	45,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	22,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	350,000.00	159,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	118,913,517.61	111,505,118.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,625,320.00	20,184,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	106,288,197.61	91,320,618.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,597.06	112,713,906.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	112,713,867.17
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	68,937,867.17
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	43,776,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	45,597.06	39.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,597.06	39.11

Жаргалант сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(88,786,413.99)	(123,571,406.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(88,786,413.99)	(123,571,406.00)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,125,095,379.12	1,532,639,242.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,025,000.00	122,014,901.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,025,000.00	122,014,901.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,500,000.00	122,014,901.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	-
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	-	122,014,901.00
120009	Бусад орлого	525,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,121,070,379.12	1,410,624,341.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,017,700.00	43,439,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,017,700.00	43,439,100.00
1330	Төсвийн захирагчдаас	-	113,423,019.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	-	113,423,019.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,095,052,679.12	1,253,762,222.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,095,052,679.12	1,253,762,222.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,126,980,610.95	1,499,739,579.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,126,980,610.95	1,499,739,579.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,126,935,013.89	1,387,025,673.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	826,219,012.88	994,733,412.65
210101	Үндсэн цалин	445,600,913.00	440,551,614.69
210102	Нэмэгдэл	276,802,273.88	406,029,063.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,494,187.00	32,977,900.00
210104	Урамшуулал	69,856,639.00	115,174,834.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,465,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,263,788.57	129,311,100.00
210201	Тэтгэврийн даатгал	73,718,926.77	86,923,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,418,808.20	10,573,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,754,254.10	5,329,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,602,100.00	5,329,200.00

Жаргалант сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	14,769,699.50	21,155,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,472,102.94	23,919,360.89
210301	Гэрэл, цахилгаан	5,172,102.94	3,819,360.89
210302	Түлш, халаалт	16,000,000.00	19,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	74,698,019.40	62,207,532.00
210401	Бичиг хэрэг	4,549,850.00	8,975,100.00
210402	Тээвэр, шатахуун	58,689,470.00	34,822,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,249,999.40	5,240,132.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,572,700.00	2,687,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,636,000.00	10,482,200.00
2105	Нормативт зардал	74,484,570.10	113,794,690.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	52,646,220.10	87,053,290.00
210502	Хоол, хүнс	21,838,350.00	17,801,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	8,940,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,646,700.00	21,648,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,036,500.00	36,000.00
210604	Урсгал засвар	10,610,200.00	21,612,200.00
2107	Томилолт, зочны зардал	3,300,000.00	15,003,050.00
210702	Дотоод албан томилолт	3,300,000.00	15,003,050.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,050,000.00	8,631,478.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	7,137,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	1,244,178.00
210803	Даатгалын үйлчилгээ	50,000.00	22,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	45,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	22,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	350,000.00	159,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,800,820.00	17,776,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,800,820.00	17,776,850.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,597.06	112,713,906.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	112,713,867.17
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	68,937,867.17
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	43,776,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	45,597.06	39.11

Жаргалант сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,597.06	39.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(1,885,231.83)	32,899,662.18
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,800,000.00	33,040,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,800,000.00	33,040,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,800,000.00	33,040,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,800,000.00	33,040,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,800,000.00)	(33,040,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(3,685,231.83)	(140,337.82)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		550,137.37
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	550,137.37	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	256,039,232.37	221,299,986.51	103,056,168.93	580,395,387.81
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	256,039,232.37	221,299,986.51	103,056,168.93	580,395,387.81
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	187,626,528.95	187,626,528.95
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	256,039,232.37	221,299,986.51	290,682,697.88	768,021,916.76
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	256,039,232.37	221,299,986.51	290,682,697.88	768,021,916.76
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	256,039,232.37	221,299,986.51	290,682,697.88	768,021,916.76
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(123,571,406.00)	(123,571,406.00)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	256,039,232.37	221,299,986.51	167,111,291.88	644,450,510.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,628,334,800.00	1,533,189,340.37	95,145,459.63	5.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,628,334,800.00	1,533,189,340.37	95,145,459.63	5.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,460,851,600.00	1,420,475,473.20	40,376,126.80	2.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,001,946,800.00	994,733,412.65	7,213,387.35	0.7
210101	Үндсэн цалин	526,250,600.00	440,551,614.69	85,698,985.31	16.3
210102	Нэмэгдэл	323,398,100.00	406,029,063.96	(82,630,963.96)	(25.6)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,674,700.00	32,977,900.00	(24,303,200.00)	(280.2)
210104	Урамшуулал	143,623,400.00	115,174,834.00	28,448,566.00	19.8

Жаргалант сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,652,800.00	129,311,100.00	341,700.00	0.3
210201	Тэтгэврийн даатгал	87,142,300.00	86,923,600.00	218,700.00	0.3
210202	Тэтгэмжийн даатгал	10,605,300.00	10,573,900.00	31,400.00	0.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,347,500.00	5,329,200.00	18,300.00	0.3
210204	Ажилгүйдлийн даатгал	5,347,500.00	5,329,200.00	18,300.00	0.3
210205	Эрүүл мэндийн даатгал	21,210,200.00	21,155,200.00	55,000.00	0.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,939,100.00	36,939,060.89	39.11	0.0
210301	Гэрэл, цахилгаан	10,569,100.00	10,569,060.89	39.11	0.0
210302	Түлш, халаалт	25,920,000.00	25,770,000.00	150,000.00	0.6
210303	Цэвэр, бохир ус	450,000.00	600,000.00	(150,000.00)	(33.3)
2104	Хангамж, бараа материалын зардал	91,057,900.00	62,207,532.00	28,850,368.00	31.7
210401	Бичиг хэрэг	10,851,900.00	8,975,100.00	1,876,800.00	17.3
210402	Тээвэр, шатахуун	53,867,200.00	34,822,900.00	19,044,300.00	35.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,569,000.00	5,240,132.00	328,868.00	5.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,242,600.00	2,687,200.00	4,555,400.00	62.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,527,200.00	10,482,200.00	3,045,000.00	22.5
2105	Нормативт зардал	107,942,700.00	113,794,690.00	(5,851,990.00)	(5.4)
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	79,102,500.00	87,053,290.00	(7,950,790.00)	(10.1)
210502	Хоол, хүнс	19,900,200.00	17,801,400.00	2,098,800.00	10.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,940,000.00	8,940,000.00	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,926,800.00	41,668,500.00	6,258,300.00	13.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,900,000.00	19,436,000.00	464,000.00	2.3
210604	Урсгал засвар	28,026,800.00	22,232,500.00	5,794,300.00	20.7
2107	Томилолт, зочны зардал	17,270,000.00	15,003,050.00	2,266,950.00	13.1
210702	Дотоод албан томилолт	17,270,000.00	15,003,050.00	2,266,950.00	13.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,468,800.00	9,041,277.66	427,522.34	4.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,618,800.00	7,547,599.66	71,200.34	0.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,300,000.00	1,244,178.00	55,822.00	4.3
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	22,500.00	127,500.00	85.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	45,500.00	254,500.00	84.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	22,500.00	77,500.00	77.5
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	159,000.00	(159,000.00)	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,646,700.00	17,776,850.00	869,850.00	4.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,646,700.00	17,776,850.00	869,850.00	4.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	167,483,200.00	112,713,867.17	54,769,332.83	32.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	167,483,200.00	112,713,867.17	54,769,332.83	32.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	85,162,000.00	68,937,867.17	16,224,132.83	19.1
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	65,328,000.00	43,776,000.00	21,552,000.00	33.0

Жаргалант сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,993,200.00	-	16,993,200.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,476,351,700.00	1,532,639,203.00	(56,287,503.00)	(3.8)
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,439,100.00	43,439,061.00	39.00	0.0
132001	Орон нутгийн төсвөөс	43,439,100.00	43,439,061.00	39.00	0.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,432,887,500.00	1,253,762,222.00	179,125,278.00	12.5
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,432,887,500.00	1,253,762,222.00	179,125,278.00	12.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	25,100.00	235,437,920.00	(235,412,820.00)	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		113,423,019.00	(113,423,019.00)	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	25,100.00	122,014,901.00	(121,989,801.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		550,137.37	(550,137.37)	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-	0.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	0.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	0.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29	29	-	0.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	0.0
620002	Гүйцэтгэх ажилтан	22	22	-	0.0
620003	Үйлчлэх ажилтан	6	6	-	0.0

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 144,590.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрч, санхүүгийн тайланд 135,956.2 мянган төгрөгийн алдаанд залруулга хийлгэлээ.

Залруулгын алдаа:

- ✓ *Үр дүнгийн тайланд орлого дутуу тусгасан 3,729.5 мянган төгрөг,*
- ✓ *Санхүүгийн тайланд үлдэгдэл баталгаажуулаагүй 11,216.5 мянган төгрөгийн өр буруу тусгасан*
- ✓ *Мөнгөн хөрөнгийн тайланд орлого давхардуулсан тусгасан 120,894.9 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгийн тайланд ,*
- ✓ *Төсвийн гүйцэтгэлийн тайланг цэвэр гүйцэтгэлээр тайлагнаагүй 115.1 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тус тус 2026.,,,,,-ны ,, тоот албан бичгээр залруулсан*

Аудитаар залруулагдаагүй 8,634.4 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 1 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага, 5 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь 8,634.4 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 18,187.7 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Байр ашиглалтын зардалтай холбоотой

Илрүүлэлт: Орон нутгаас олгож байгаа тогтмол зардлын санхүүжилтээс байр ашиглалтын зардалтай холбоогүй урсгал зардал болох машины сэлбэг худалдан авч зориулалт бус зарцуулсан 2,768.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо

5.2 Албан шаардлага

5.2.1 Тендер худалдан авалттай холбоотой

Илрүүлэлт: Эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуурыг тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдээс худалдан аваагүй, ААЭМГ/20250102001 дугаартай гэрээний хэрэгжилт хангалтгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31-р зүйлийн 31.2-т “Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох гэрээний үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлээ

5.2.2 НББ, тайлагналтай холбоотой

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгө данснаас хасахдаа төрийн өмчийн албан тоотой хассан боловч албан тоот нь нэр төрлөөр жагсааж хавсралт батлаагүй, хөрөнгийн үнэлгээ хэрхэн хийсэн нь тодорхой бус, акталсан хөрөнгийг устгах тушаал шийдвэргүй, устгалтын акт үйлдээгүй, хөрөнгө ангилан бүртгээгүй зөрчил тус тус илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 16-р зүйлийн 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож дахин гаргахгүй байх хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлээ

5.3 Зөвлөмж

5.3.1 Эм, боох материалын худалдан авах ажиллагаатай холбоотой

Илрүүлэлт: Ерөнхий гэрээгээр жагсаалтад орсон эм, эмийн хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, төсвийг зохистой удирдаж, дотоод хяналт хэрэгжүүлээгүй 3,067.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.4-д “Цахим дэлгүүрт байршсан бараа үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж дотоод хяналтыг сайжруулах

5.3.2 НББ, тайлагналтай холбоотой

Илрүүлэлт: НББ-ийн ОУ-ын стандартад нийцүүлэн эм, боох материалын дансанд бүртгэлтэй тусгай зориулалтын материалыг зөв ангилан бүртгээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2 -д "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын тооллогыг чанартай хэрэгжүүлэх, НББ-ийн ОУ-ын стандартын дагуу бараа материалыг ангилан бүртгэх

5.3.3 Бараа материалын худалдан авах ажиллагаатай холбоотой

Илрүүлэлт: Хоол хүнсийг худалдан авахдаа сумын нэгдсэн тендер шалгаруулалтад санал өгөөгүй, бусад шалгарсан тендерийн үнээс өндөр үнээр хүнс нийлүүлж байгаа, хүнсний эрүүл ахуй гарал үүслийн бичиг байхгүй хүнс худалдан авсан зөрчил илэрлээ.

Энэ нь Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.15.2-д "энэ хуулийн 27.2, 27.5, 27.7.5-д заасан гэрчилгээгүй бүтээгдэхүүн худалдан авах тээвэрлэх, зөөвөрлөхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүнсний бүтээгдэхүүнийг зохих хууль, журмын дагуу худалдан авах,

5.3.4 Нэмэгдэлтэй цалин хөлстэй холбоотой

Илрүүлэлт: Шөнийн нэмэгдлийг ЭМС-ын 2020 оны А/69 тоот тушаал шийдвэрийн дагуу олгоогүй, илүү цаг шөнийн нэмэгдлийг тус тусад нь бодоогүй 2,798.9 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2 -д "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль журмын дагуу илүү цагийг бодож олгох

5.3.5 Шатахууны зардалтай холбоотой

Илрүүлэлт: Жолоочийн замын хуудсыг алсын дуудлага болон дотоод ажлаар явсан хүний гарын үсгээр баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2 -д "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шатахууны тооцоог эрх бүхий хүний гарын үсгээр баталгаажуулж тооцоо бодож хэвших

Жаргалант сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Архангай аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Жаргалант ЭМТ	Үр дүнгийн тайланд орлого бүрэн тусгаагүй	1	3,729.5	1	3,729.5			1	3,729.5		
	Мөнгөн хөрөнгийн тайланд орлого илүү тусгасан	1	120,894.9			1	120,894.9	1	120,894.9		
	Санхүүгийн тайланд тооцоо нийлж баталгаажаагүй өр буруу тусгасан	1	11,216.7			1	11,216.7	1	11,216.7		
	Төсвийн гүйцэтгэлийн тайланг цэвэр гүйцэтгэлээр тайлагнаагүй	1	115.1			1	115.1	1	115.1		
Нийт дүн		4	135,956.2	1	3,729.5	3	132,226.7	4	135,956.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллага		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Жаргалант сумын ЭМТ	Эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуурыг тендэрт шалгарсан аж ахуйн нэгжүүдээс худалдан аваагүй, ААЭМГ/20250102001 дугаартай гэрээний хэрэгжилт хангалтгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй	1	-			1						
	Үндсэн хөрөнгө данснаас хасахдаа төрийн өмчийн албан тоотор хассан боловч албан тоот нь нэр төрлөөр жагсааж хавсралт батлаагүй, хөрөнгийн үнэлгээ хийгээгүй, акталсан хөрөнгийг устгах тушаал шийдвэргүй, устгалтын акт үйлдээгүй	1	-				1					
	Ерөнхий гэрээгээр жагсаалтанд орсон эм эмийн хэрэгсэлийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, төсвийг зохистой удирдаж, дотоод хяналт хэрэгжүүлээгүй	1	3,067.5						1	3,067.5		
	Хоол хүнсийг худалдан авахдаа сумын нэгдсэн тендер шалгаруулалтанд санал өгөөгүй, шалгарсан тендерийн үнээс өндөр үнээр хүнс худалдан авсан, нийлүүлж байгаа хүнсний эрүүл ахуй гарал үүслийн бичиг байхгүй, Засаг даргын А/50 тоот захирамжийн биелэлт хангалтгүй	1	-						1			
	Шөнийн нэмэгдлийг ЭМС-ын 2020 оны А/69 тоот тушаал шийдэрийн дагуу олгоогүй	1	2,798.9						1	2,798.9		
	Орон нутгаас олгож байгаа тогтмол зардлын санхүүжилтээс байр ашиглалтын зардалтай холбоогүй урсгал зардал болох машины сэлбэг худалдан авч зориулалт бус зарцуулсан	1	2,768.0		1	2,768.0						
	НББ-ийн ОУ-ын стандартад нийцүүлэн эм, боох материалын дансанд бүртгэлтэй тусгай зориулалтын материалыг зөв ангилан бүртгээгүй	1	-						1			
	Жолоочийн замын хуудсыг алсын дуудлага болон дотоод ажлаар явсан хүний гарын үсгээр баталгаажуулаагүй	1	-						1			
Нийт дүн		8	8,634.4	1	2,768.0	2	-	5	5,866.4			